

0. Статистик тайлан илгээх заавар

ЕБС -ийн статистик тайлан илгээх хугацаа нээгдсэн үед сургалтын менежер дараах бүртгэл үйл ажиллагааг хийнэ.

1. **Дэд модулиар бүртгэгдэж тайланд тусгагдах судалгааг хийх.** /Зарим тайланд сургуулийн хэмжээний нэгтгэсэн мэдээллийг менежер бүртгэдэг. Жишээлбэл: "**Сурах бичиг, Сурдаггүй хүүхэд**" тайлант хугацааны үед тухайн сургуульд сурахгүй шалтгаантай суралцагч байдаг бол **Сурдаггүй хүүхэд** дэд модульд бүртгэн хадгална./

2. Тайлан бодуулж excel-рүү татан, хянаж тоо таарч буй үед илгээх

Аливаа тайлант үе нээгдсэний дараа тухайн тайланд бүртгэх мэдээллийг хариуцсан албан тушаалтан судалгаа мэдээллийг үнэн зөв бүртгэнэ.

Дээрх бүртгэл бүрэн хийгдсэн үед сургалтын менежер

Статистикийн удирдлага -> Статистик хяналт дэд модулийг сонгоно.

1-рт: **Нэгтгэл -> Бүгдийг шинэчлэх** товчийг дарна. /Аливаа мэдээлэл шинэчлэн, нөхөж бүртгэсэн бол энэ товчийг заавал дарах юм. Хэрэв энэ товчыг дарсан бол тайлангуудыг дахин бодуулах шаардлагатай./

2-рт: **Тайлан - Хичээлийн жил, тайлангийн нэр** сонгож тайлангуудыг бодуулан excel -рүү татаж тоог тулган хянана.

3-рт: **Тайлангуудын** excel файлуудын бүх тоо таарч буй үед **илгээх** товчийг сонгоно.

1. Ажилтан, суралцагч, бүлэг, дүрэмт хувцас тайлан гаргах зааварчилгаа

Бага дунд боловсрол

Бага, дунд боловсрол (БДБ)-ын статистикийн мэдээллийг албан ёсны 7, захиргааны 59, нийт 66 маягтаар гаргадаг.

Эдгээр статистик тайлан нь тухайн хичээлийн жилд суралцагч, ажиллагчдын болон сургалтын орчин, зардлын гүйцэтгэлийн тухай мэдээллийг гарган,

Боловсрол, соёл урлагийн газарт хүргүүлэхэд ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэх үйл ажиллагааны хугацааг дор дурдсанаар тогтоосон болно.

Статистикийн мэдээллийн ангилал, нэр		ЕБС-иас БСУГ-т мэдээлэл ирүүлэх эцсийн хугацаа
БДБ - 1	ЕБС-т өдрөөр суралцагчдын тайлан /анги, бүлэг, нас, хүйс /	9 сарын 15
1Д - БДБ	ЕБС-т суралцаж байгаа бүтэн өнчийн хүүхдийн тайлан /өмчийн хэлбэр, сургалтын хэлбэр, нас/	
2- БДБ	ЕБС-т өдрөөр суралцагчдын тайлан /үндсэн захиргаа харъяалал, нас, хүйс /	
3- БДБ	ЕБС-т суралцагчдын шилжих хөдөлгөөний тайлан /өмчийн хэлбэр, анги, хүйс/	
4- БДБ	ЕБС-ийн нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн тайлан /өмчийн хэлбэр, нас, хүйс/	
5- БДБ	ЕБС-ийн гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын бүлэг, хамрагдагчдын тайлан / анги, хичээл, мэргэжлийн чиглэл/	
6- БДБ	ЕБС-ийн дотуур байр, амьдарч буй суралцагчид, ажиллагчдын тайлан /анги, хүйс/	
7- БДБ	ЕБС-ийн дотуур байр, амьдарч буй суралцагчид, ажиллагчдын тайлан /анги, хүйс/	
7Б- БДБ	АББ-ын гэгээрлийн төвд ажиллагчдын тайлан /нас, хүйс,	

	боловсролын түвшин, мэргэжлийн зэрэг/	
8- БДБ	ЕБС-ийн удирдах ажилтан, нийгмийн ажилтан, үндсэн багшийн шилжих хөдөлгөөний тайлан /хүйс/	
9- БДБ	ЕБС-ийн удирдах ажилтан, нийгмийн ажилтны тайлан /мэргэжлийн чиглэл, хүйс /	
9Б- БДБ	ЕБС-ийн удирдах ажилтан, нийгмийн ажилтны тайлан /нас, хүйс, боловсролын түвшин, мэргэшлийн чиглэл/	
10- БДБ	ЕБС-ийн багш нарын тайлан /нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн зэрэг/	
11- БДБ	ЕБС-ийн орой, эчнээгээр хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын тайлан /нас, хүйс, анги/	
11Б- БДБ	ЕБС-ийн оройгоор хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын тайлан /нас, хүйс, анги/	
11Г- БДБ	ЕБС-ийн эчнээгээр хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын тайлан /нас, хүйс, анги/	
12- БДБ	Дүйцсэн хөтөлбөрөөр хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын тайлан /нас, хүйс/	
14- БДБ	ЕБС-ийн сурах бичгийн хангалтын тайлан /ангиар/	10 сарын 15
15- БДБ	ЕБС-ийн гадна байгаа 6-14 насны хүүхдийн тайлан /нас, хүйс, шалтгаан/	
16- БДБ	ЕБС-ийн тайлан / өмчийн хэлбэр, хэв шинж, сургалтын хэлбэр /	9 сарын 15
17- БДБ	ЕБС-ийн сургалтын орчны тайлан /өмчийн хэлбэр/	2 сарын 1
18- БДБ	ЕБС-ийн сургалтын орчны тайлан /өмчийн хэлбэр/	1 сарын 20
19- БДБ	ЕБС-д шаардлагатай багшийн тайлан /өмчийн хэлбэр, мэргэжлийн чиглэл/	9 сарын 15, 6 сарын 15
20- БДБ	ЕБС-ийг төгсөгчдийн тайлан /сургалтын хэлбэр, хүйс/	6 сарын 15
20Б- БДБ	Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг төгсөгчдийн тайлан /нас, хүйс/	
21- БДБ	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан /өдөр, орой, эчнээ, дүйцсэн хэлбэрээр тус тусад нь гаргана /	

Албан ёсны мэдээлэл, Маягт БДБ-1–д өдрийн сургалтаар бага, суурь, бүрэн дунд боловсролыг олгож буй байдлыг анги, нас хүйсээр, тухайн суралцагчийн амьдралын байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийг тусгана.

Боловсролын удирдлага хэсгийн Анги бүлэг, Суралцагч модульд бүртгэл хийгсээр гарна.

№	БДБ тайлангийн нэр	Тайлбар
1	БДБ-1	ЕБС-д өдрөөр суралцагчдын тайлан (анги, бүлэг, нас, хүйс) Өдрөөр суралцагчийн анги,бүлэг, нас, хүйс, малчдын хүүхэд, гадаадын иргэн харьяат, бүтэн өнчин, асрамжлах хүнгүй, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт бүртгэл харагдана.
2	БДБ-1А	ЕБС-д бүлгийн тайлан (сургууль, бүлэг, боловсролын түвшин) Сургуулийн ангилал, анги, бүлгийн тоо, суралцагчдын тоо нь хичээллэх ээлж тус бүрээр харагдана.
3	БДБ-1Б	ЕБС-д өдрөөр суралцагчдын тайлан (сургууль, нас, хүйс) Өдрөөр суралцагчид нь насаар, малчдын хүүхэд, гадаадын харьяат, асрамжлах хүнгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо харагдана.
4	БДБ-1В	ЕБС-д өдрөөр суралцагчдын тайлан (сургууль, анги, хүйс) Өдрөөр суралцагчид анги, хүйсээр харагдана.
5	БДБ-1Д	ЕБС-д суралцаж байгаа бүтэн өнчин хүүхдийн тайлан (сургууль) Бүтэн өнчин хүүхдийн суралцах хэлбэр, нас, амьдарч буй газар, асран хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй эсэх бүртгэл харагдана.

БДБ 1 маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа

1. Өдрийн сургалтад хамдагдаж байгаа хүүхэд болон бүлгийг тоолохдоо:

Боловсролын удирдлага системийн **Анги бүлэг** үйл ажиллагааны бүлгийн ангилал нь үндсэн бүлэг гэсэн сонголттой, хичээллэх ээлжийн сонголт хийсэн, **Суралцагч** үйл ажиллагааны сургалтын ээлж талбар нь өдөр гэж сонгогдсон суралцагчид

2. Малчдын хүүхэд гэдэгт

Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны Суралцагчийн хувийн мэдээлэл -ийн **Нэмэлт мэдээлэл** хэсгийн **Өрхийн мэдээлэл**-ийн "Эцэг эх аль нэг нь малчин эсэх" талбарт Тийм (чеклэсэн) гэж сонгосон суралцагчийг тоолно.

3. Гадаадын харьяат гэдэгт

Боловсролын удирдлагын системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны Суралцагчийн хувийн мэдээлэл -ийн **Холбоо барих** хэсгийн харьяалал хаягт монгол улсаас өөр гадаад улс гэдэг сонголттой суралцагчийг тоолно.

4. Бүтэн өнчин гэдэгт

Боловсролын удирдлага системийн "Суралцагч" үйл ажиллагааны Суралцагчийн хувийн мэдээллийн Үндсэн мэдээлэл хэсгийн "Өнчний төрөл" талбарт "Бүтэн өнчин" гэж сонгосон суралцагчийг тоолно.

5. Асрамжлах хүнгүй гэдэгт

Боловсролын удирдлага системийн "Суралцагч" үйл ажиллагааны Суралцагчийн хувийн мэдээллийн Үндсэн мэдээлэл хэсгийн "Асран хамгаалагч" талбарт "Асрамжлах хүнгүй" гэж сонгосон суралцагчийг тоолно.

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд - Төрөл:

-Төрөлхийн

Боловсролын удирдлага системийн "Суралцагч" үйл ажиллагааны "Суралцагчийн хувийн мэдээллийн" **Эрүүл мэнд** хэсгийн "Хөгжлийн бэрхшээлтэй" талбарт "Үгүй" гэснээс бусдыг сонгосон, төрөл талбарт **Төрөлхийн**, үндсэн шалтгаан Төрөлхийн гэж сонгогдсон суралцагчийг тоолно.

-Олдмол

Боловсролын удирдлагын системийн "Суралцагч" үйл ажиллагааны "Суралцагчийн хувийн мэдээллийн" **Эрүүл мэнд** хэсгийн "Хөгжлийн бэрхшээлтэй" талбарт "Үгүй" гэснээс бусдыг сонгосон, төрөл талбарт **Олдмол**, үндсэн шалтгаан **Өвчин, Осол, Төрөлхийн** сонголтын аль нэг нь сонгогдсон суралцагчийг тоолно.

БДБ 1Д маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа

ЕБС-д суралцаж байгаа бүтэн өнчин хүүхдийг тоолохдоо:

1. Сургалтын хэлбэрийн төрөл:

- **Өдөр** - Боловсролын удирдлага системийн "Суралцагч" үйл ажиллагааны Суралцагчийн хувийн мэдээллийн Үндсэн мэдээлэл хэсгийн "Өнчний төрөл" талбарт - "Бүтэн өнчин" гэж сонгосон, мөн **Суралцагч** үйл ажиллагааны сургалтын ээлж талбарт өдөр гэсэн сонголттой суралцагчийг тоолно.

- **Орой** -Боловсролын удирдлага системийн "Суралцагч" үйл ажиллагааны Суралцагчийн хувийн мэдээллийн Үндсэн мэдээлэл хэсгийн "Өнчний төрөл" талбарт "Бүтэн өнчин" гэж сонгосон, Хэрэгжүүлдэг **сургалтын хөтөлбөр** нь /Ж: Суурь боловсролын сургалтын хөтөлбөр -орой/ гэсэн сонголттой мөн **Суралцагч** үйл ажиллагааны сургалтын ээлж талбарт орой гэсэн сонголттой суралцагчийг тоолно.

- **Эчнээ** - Боловсролын удирдлага системийн "Суралцагч" үйл ажиллагааны Суралцагчийн хувийн мэдээллийн Үндсэн мэдээлэл хэсгийн "Өнчний төрөл" талбарт "Бүтэн өнчин" гэж сонгосон, Хэрэгжүүлдэг **сургалтын хөтөлбөр** нь /Ж: Суурь боловсролын сургалтын хөтөлбөр -эчнээ/ гэсэн сонголттой мөн **Суралцагч** үйл ажиллагааны сургалтын ээлж талбарт эчнээ гэсэн сонголттой суралцагчийг тоолно.

- **Дүйцсэн** - Боловсролын удирдлага системийн "Суралцагч" үйл ажиллагааны Суралцагчийн хувийн мэдээллийн Үндсэн мэдээлэл хэсгийн "Өнчний төрөл" талбарт "Бүтэн өнчин" гэж сонгосон,Хэрэгжүүлдэг **сургалтын хөтөлбөр** нь /Ж: Суурь боловсролын сургалтын хөтөлбөр -дүйцсэн/ гэсэн сонголттой мөн **Суралцагч** үйл ажиллагааны сургалтын ээлж талбарт дүйцсэн гэсэн сонголттой суралцагчийг тоолно.

2. Амьдарч буй сууц:

- **Өөрийн гэрт** - Боловсролын удирдлага системийн "Суралцагч" үйл ажиллагааны "Нэмэлт

мэдээлэл" хэсгийн "Амьдрах орчин" хэсэгт **"Амьдарч буй газар"** талбарт **"өөрийн гэрт"** гэж сонгосон суралцагчийг тоолно.

- **Төрөл садангийндаа** - Боловсролын удирдлага системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны "Нэмэлт мэдээлэл" хэсгийн "Амьдрах орчин" хэсэгт **"Амьдарч буй газар"** талбарт **"төрөл садангийндаа"** гэж сонгосон суралцагчийг тоолно.

- **Дотуур байранд** - Боловсролын удирдлага системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны "Нэмэлт мэдээлэл" хэсгийн "Амьдрах орчин" хэсэгт **"Амьдарч буй газар"** талбарт **"дотуур байр"** гэж сонгосон суралцагчийг тоолно.

- **Асрамжийн газар** - Боловсролын удирдлага системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны "Нэмэлт мэдээлэл" хэсгийн "Амьдрах орчин" хэсэгт **"Амьдарч буй газар"** талбарт **"асрамжийн газар"** гэж сонгосон суралцагчийг тоолно.

- **Бусад** - Боловсролын удирдлага системийн **"Суралцагч"** үйл ажиллагааны "Нэмэлт мэдээлэл" хэсгийн "Амьдрах орчин" хэсэгт **"Амьдарч буй газар"** талбарт **"бусад"** гэж сонгосон суралцагчийг тоолно.

Тухайн бүртгэлийг шалгахдаа дараах байдлаар харна. Үүнд:

1. Маягтаар

БДБ-1, БДБ-1А, БДБ-1Б, БДБ-1В маягтын нийт суралцагчдын тоо нь ижил байна.

2. Бүртгэлээр

2. Статистикийн удирдлага -ийн статистикийн хяналт хэсэгт орно.

Хяналтын хэсэгт хичээлийн жил болон тайлант үеийг сонгоно.

Нэгтгэл цонхноос суралцагч гэсэн утгыг дуудна. Ингэснээрээ танай сургуулийн суралцагчид анги, бүлэг тус бүрийн мэдээлэл нь нэгдсэн байдлаар харагдана.

Тайлан болон бүртгэлийг шалгаад буруу эсвэл залруулах шаардлагтай гэж үзвэл дараах холбоосоор орж цахим гарын авлагатай танилцана уу.

Анги бүлэг үүсгэх, засах, устгах заавар - <https://help.esis.edu.mn/cat/528>

Суралцагч бүртгэх, суралцагчийн бүлэг солих, суралцагчийн хөтөлбөр солих заавар - <https://help.esis.edu.mn/cat/527>

БДБ-2 Маягт нь Суралцагчийн нас, харьяаллын мэдээллийг харуулна.

Суралцагчийн харьяаллын мэдээллийг гаргахдаа тухайн үед хаана оршин суух бүртгэлтэйг харгалзана.

Тухайлбал: Ховд аймагт төрсөн боловч Сэлэнгэ аймагт шилжин ирж, сум хороондоо бүртгүүлсэн бол орон нутгийн харьяаллыг Сэлэнгэ аймгийнх гэж тооцно.

Харин албан ёсоор тухайн аймаг хотод /сум, дүүрэгт/ шилжин ирээгүй сурагчдыг албан ёсны бүртгэлтэй аймаг, хотоор нь гаргана.

Тухайлбал: Сэлэнгэ аймагт суралцаж байгаа Төв аймгийн Баяндэлгэр сумын хүүхдийг Төв аймгийн харьяат гэж үзнэ.

Тухайн бүртгэлийг шалгахдаа дараах байдлаар харна. Үүнд:

1. Маягтаар

Энэ маягтын нийт хүүхдийн тоо нь БДБ-1 маягтын суралцагчдын тоотой ижил байна.

Энэ маягтын 24-р мөр буюу гадаадын харьяат хүүхдийн тоо нь БДБ-1 маягтын 32-р багана буюу гадаадын харьяат хүүхдийн тоотой ижил байна.

2. Бүртгэлээр

Статистикийн удирдлага -ийн статистикийн хяналт хэсэгт орно.

Хяналтын хэсэгт хичээлийн жил болон **тайлант үе**-ийг сонгоно.

Нэгтгэл цонхноос **суралцагч** гэсэн утгыг дуудна. Ингэснээрээ танай сургуулийн суралцагчид анги, бүлэг тус бүрийн мэдээлэл нь нэгдсэн байдлаар харагдана.

Жагсаалт гэсэн хэсгээс суралцагч тус бүрийн харьяалалын мэдээллийг харж болно.

Тайлан болон бүртгэлийг шалгаад буруу эсвэл залруулах шаардлагтай гэж үзвэл дараах холбоосоор орж цахим гарын авлагатай танилцана уу.

Суралцагчийн хувийн мэдээлэл бүртгэх заавар - <https://help.esis.edu.mn/content/545>

Уг тайлан нь тухайн сургуулийн суралцагчдын шилжилт хөдөлгөөн болох тайлант хугацаанд нэмэгдсэн, хасагдсан суралцагчдын тоог **шууд боловсруулагдан** харуулна.

Тухайн бүртгэлийг шалгахдаа дараах байдлаар харна. Үүнд:

1.Маягтаар

1. Энэхүү маягтын 01 дүгээр мөрөнд байгаа тайлангийн хугацааны эхэнд байсан хүүхдийн тоо нь өнгөрсөн хичээлийн жилд өгсөн БДБ-1 маягтын 05-р баганад бичигдсэн хүүхдийн тоотой ижил байна.

2. Энэхүү маягтын 57-р мөрөнд байгаа "Тайлан гаргах үед байгаа" хүүхдийн тоо нь БДБ-1 тайлангийн 01 -р мөрний 05 -р баганад байрлах нийт суралцагчдын тоотой ижил байна.

Албан ёсны мэдээлэл, Маягт БДБ-4

Төрийн бус өмчийн сургууль, холимог өмчийн хөрөнгө оруулалттай сургуульд тухайн хичээлийн жилд нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн мэдээллийг нас, хүйс болон сургуульд орохын өмнө сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан эсэх мэдээллийг харуулна.

Тухайн бүртгэлийг шалгахдаа дараах байдлаар харна. Үүнд:

1. Маягтаар

Уг маягтын 01-р мөр 01, 02-р баганад байх 1-р ангид элсэгчдийн тоо БДБ-1 маягтын 05, 06 -р мөрний 05-р багананы дүнтэй тэнцүү байна.

Уг маягтын 01-р мөр 01, 02-р баганад байх 1-р ангид элсэгчдийн тоо БДБ-3 маягтын 02-р багананы 59,60 дугаар мөрний дүнтэй тэнцүү байна.

2. Бүртгэлээр

Статистикийн удирдлага-ийн статистикийн хяналт хэсэгт орно.

Нэгтгэл цонхноос **Суралцагч** гэсэн хэсгийг дуудна.

Суралцагчийн жагсаалт хэсэгт орж excel хэлбэрээр татан авч шүүж 1-р ангийн суралцагчдын хайлтыг хийж СӨБ-д хамрагдсан эсэхийг хүүхэд тус бүрээр нь шалгах боломжтой.

БДБ 4 маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа

Нэгдүгээр ангид шинээр элсэгчийг тоолохдоо:

Боловсролын удирдлагын системийн "**Суралцагч**" үйл ажиллагааны "**Шинэ суралцагч**" бүртгэж авахдаа "Үйлдлийн шалтгаан" дээр нь "**Шинээр элссэн**" гэж сонгосон суралцагчийг тоолно.

Хэрэв таны гаргасан **БДБ1, БДБ4** тайлангийн 1-р ангийн суралцагч зөрүүтэй байгаа тохиолдолд 1-р ангид бүртгэсэн суралцагчийн хувийн мэдээлэл хэсгээс **Хөтөлбөр, төлөвлөгөө** хэсэгт дарж **Мэдээлэл засах** үйлдэл хийж "**Үйлдлийн мэдээлэл**" хэсэгт байрлах "**Үйлдлийн шалтгаан**" -аас "**Шинээр элссэн**" гэж сонголт хийнэ.

**ЕБС -ийн гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын бүлэг,
хамрагдагчдын тайлан**

Статистикийн удирдлага модулийн “Байгууллагын асуулга” -н “Гүнзгийрүүлсэн сургалт” ,
“Төрөлжсөн сургалт” хэсгүүдийг бөглөж, хадгалсан мэдээллээс БДБ-5, БДБ-5А тайланг боловсруулж
гаргана.

№	БДБ тайлангийн нэр		Тайлбар
1	БДБ-5	ЕБС-д гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын бүлэг, хамрагдагчдын тайлан (анги, чиглэл)	Байгууллагын асуулгын Гүнзгийрүүлсэн сургалт, Төрөлжсөн сургалт хэсгүүдийг бөглөснөөр гарна.
2	БДБ-5А	ЕБС-д гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын бүлэг, хамрагдагчдын тайлан (сургууль, чиглэл)	Байгууллагын асуулгын Гүнзгийрүүлсэн сургалт, Төрөлжсөн сургалт хэсгүүдийг бөглөснөөр гарна.

Албан ёсны мэдээлэл, Маягт БДБ-6

Дотуур байрны хүчин чадал, түүний орчин болон дотуур байранд амьдрах хүсэлтэй болон амьдарч байгаа хүүхдийн мэдээллийг анги, хүсээр харуулна.

БДБ 6 маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа

1. Дотуур байрны бүртгэлийг тоолохдоо:

Боловсролын удирдлага системийн **Сургалтын орчин** үйл ажиллагаанд Шинэ байр үүсгэж түүний үндсэн зориулалт хэсэгт **"дотуур байр"** гэсэн сонголттой, ашиглаж байгаа эсэх чек /идэвхижүүлэх/ хийсэн байрыг тоолно.

2. Стандартын эсэх

Тухайн барилгын мэдээлэл рүү орж стандартын эсэх гэснийг чек /идэвхижүүлэх/ хийснээр стандартын гэж тоолно.

3. Үүсгэж буй өрөөний төрлөөс шалтгаалан хүүхэд байрлах, тоглоом амралт, номын сан, эрүүл мэндийн, халуун усны өрөөнүүдийг тоолно.

4. Эд хогшил бүртгэх

Тухайн байранд байрладаг суултуур, угаалтуурыг тоог бүртгэнэ.

5. Инженерийн шугам сүлжээнд холбогдсон эсэх

Дотуур байрны инженерийн шугам сүлжээнд холбогдсон эсэх мэдээллийг оруулахдаа **Боловсролын удирдлага** -ын **Сургалтын орчин** үйл ажиллагааны байрны мэдээлэл рүү орж **Дэд бүтэц** хэсэгийн **Төрөл** дээр нь Инженерийн шугам сүлжээ, **Хэлбэр** дээр нь Төвлөрсөн инженерийн шугам сүлжээ сонгосноор тоолно.

БДБ 6-ийн үргэлжлэл маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа

6. Дотуур байранд суух хүсэлт гаргасан хүүхдийн бүртгэлийг тоолохдоо:

Боловсролын удирдлагын системийн "Суралцагч" үйл ажиллагааны Суралцагчийн хувийн мэдээлэл -ийн **Нэмэлт мэдээлэл** хэсгийн **Дотуур байр**-ийн "Дотуур байранд суух хүсэлт гаргах" талбарт дэлгэрэнгүй бүртгэлийн **Төлөв** хэсэгт "Хүсэлт гаргасан" гэж сонгосон суралцагчийг тоолно.

7. Дотуур байранд амьдарч буй хүүхдийн бүртгэлийг тоолохдоо:

Боловсролын удирдлагын системийн "Суралцагч" үйл ажиллагааны Суралцагчийн хувийн мэдээлэл -ийн **Нэмэлт мэдээлэл** хэсгийн **Дотуур байр**-ийн "Дотуур байранд суух хүсэлт гаргах" талбарт дэлгэрэнгүй бүртгэлийн **Төлөв** хэсэгт "Байрандаа орсон" гэж сонгосон суралцагчийг тоолно.

8. Дотуур байранд ажиллагсдыг тоолохдоо:

Статистикийн удирдлага -ын Байгууллагын асуулга хэсэгт дотуур байрны ажиллагчид гэсэн хэсэгт бүртгэл хөтлөснөөр үг тайланд тоологдоно.

Тухайн бүртгэлийг шалгахдаа дараах байдлаар харна. Үүнд:

1. Маягтаар

Тайлангийн хэсгээс БДБ 6 тайлангийн 42-р мөрийн тоо нь БДБ 7-р тайлангийн 12-р мөрийн тоотой ижил байх

2. Бүртгэлээр

Статистикийн удирдлага -ийн **статистикийн хяналт** хэсэгт орно.

Хяналтын хэсэгт хичээлийн жил болон **тайлант үе**-ийг сонгоно.

Нэгтгэл цонхноос **суралцагч** гэсэн утгыг дуудна. Ингэснээрээ танай сургуулийн суралцагчид анги, бүлэг тус бүрийн мэдээлэл нь нэгдсэн байдлаар харагдана.

Товчоо гэсэн хэсгээс бүх анги бүлгүүдийн **дотуур байранд амьдардаг** суралцагчдын тоог харж болно.

Албан ёсны мэдээлэл, Маягт БДБ-7

БДБ-7 маягтаар тухайн сургуульд Төрийн албаны ангиллын дагуу ажиллаж байгаа ажиллагчдыг удирдах, үйлчилгээний ажиллагчид гэсэн ангилал буюу албан тушаал тус бүрээр нь гаргана.

№	БДБ тайлангийн нэр		Тайлбар
1	БДБ-7	ЕБС-ийн ажилчдын тайлан (хүйс)	Хүний нөөцийн удирдлага хэсгийн Ажлын байр, Ажилтны жагсаалт модульд бүртгэл хийгсээр гарна.
2	БДБ7А	ЕБС-ийн ажилчдын тайлан (сургууль, хүйс)	Ямар ажлын байранд хичнээн хүн бүртгэлтэй байгааг харна.
3	БДБ7_1А	Албан бус боловсролын гэгээрэл хөгжлийн төвийн ажилчдын тайлан (сургууль)	Тухайн сургууль нь албан бус боловсрол эзэмшүүлдэг бол түүний ажилчдын ажлын байрны тоог харуулна.
4	БДБ7_1	Албан бус боловсролын гэгээрэл хөгжлийн төвийн ажилчдын тайлан	Албан бус боловсролын төвийн ажилчдын нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн зэрэг гэх мэт бүртгэлийг харна.

Тухайн бүртгэлийг шалгахдаа дараах байдлаар харна. Үүнд:

1. Бүртгэлээр

Статистикийн удирдлага -ийн статистикийн хяналт хэсэгт орно.

Хяналтын хэсэгт хичээлийн жил болон тайлант үеийг сонгоно.

Нэгтгэл цонхноос **Ажилтан** гэсэн утгыг дуудна. Ингэснээрээ танай сургуулийн ажилчдын тоо нэгдсэн байдлаар харагдана.

Жагсаалт гэсэн хэсгээс ажилтан тус бүрийн албан тушаалын мэдээллийг харж болно.

Захиргааны мэдээлэл, Маягт БДБ- 8

Удирдах ажилтан, нийгмийн ажилтан, үндсэн багшийн шилжилт хөдөлгөөний маягтанд захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, үндсэн багш нарын шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг гаргана.

Тухайн бүртгэлийг шалгахдаа дараах байдлаар харна. Үүнд:

1. Маягтаар

Маягтны өмнөх тайлангийн үеийн ажиллагчид гэсэн 01 дүгээр мөрөнд өнгөрсөн хичээлийн жилийн БДБ-8 маягтын тайлан гаргах үед ажиллаж байгаа гэсэн 20-р мөрөнд байгаа дүнтэй ижил байна.

БДБ8 тайлан:

Өмнөх тайлангийн үед ажиллагчдын дүнг гаргахдаа энэ хичээлийн жилд ажиллаж байгаа ажилчдаас хасах болон нэмэх үйлдэл хийж гардаг бөгөөд **Статистикийн удирдлага** -ын "**Байгууллагын асуулга**" үйл ажиллагааны **Багш, удирдах ажилтны шилжилт хөдөлгөөн** хэсэгт бүртгэл хөтлөснөөр гарна.

Жишээ нь:

Танай сургууль өмнөх хичээлийн жилд 18 үндсэн багштай байсан. Харин энэ хичээлийн жилд 20 багштай болсон гэж үзье.

Тэгвэл БДБ 8 тайлангийн "**Өмнөх тайлангийн үед ажиллагчид**" гэдэг дүнг гаргахдаа **Статистикийн удирдлага** -ын "**Байгууллагын асуулга**" үйл ажиллагааны **Багш, удирдах ажилтны шилжилт хөдөлгөөнд** үндсэн багш гэсэн хэсэгт Тайлант хугацаанд **нэмэгдсэн** шалтгаанд тохирох утга ард 2 гэдэг тоо оруулна.

Түүний дараа тайлангаа шинэчлэн бодуулах үйлдэл хийж тайлангаа татаж үзнэ.

Захиргааны мэдээлэл, Маягт БДБ-9

Маягт БДБ-9 нь захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан нарын мэргэжил, боловсролын түвшин,

ажилласан хугацаа, мэргэжлийн зэрэг, насны талаарх мэдээллийг гаргана.

№	БДБ тайлангийн нэр		Тайлбар
1	БДБ-9	ЕБС-ийн удирдах ажилтан, нийгмийн ажилтны тайлан (мэргэжлийн чиглэл, хүйс)	ЕБС-ийн удирдах албан тушаалтны мэргэжлийн чиглэлийн харуулна.
2	БДБ-9.1	ЕБС-ийн удирдах ажилтан, нийгмийн ажилтны тайлан (нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн зэрэг)	Удирдах албан тушаалтнуудын дэлгэрэнгүй бүртгэл болон нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн зэрэг, ажилласан жил зэрэг мэдээллүүлийн харуулна.

Албан ёсны мэдээлэл. Маягт БДБ-10.

Маягт БДБ-10-д ажиллавал зохих багш, ажиллаж байгаа багш, дутагдалтай багш, түүнчлэн цагаар хичээл зааж байгаа багшийн мэргэжил тус бүрээр гаргана. Тэдгээрийн боловсролын түвшин, насны бүлэг, мэргэжлийн зэрэг, багшилсан хугацааны мэдээллийг гаргана.

№	БДБ тайлангийн нэр		Тайлбар
1	БДБ-10	ЕБС-ийн багш нарын тайлан (нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн чиглэл)	Ажиллавал зохих багш, үндсэн багш, мэргэжлийн бус багш, шаардлагатай багш, цагийн багш, үндсэн багш нарийн боловсролын түвшин, нас, багшилсан хугацаа, мэргэжлийн зэрэг, мэргэжил дээшлүүлсэн байдал зэрэг мэдээлэл харагдана.
2	БДБ-10А	ЕБС-ийн үндсэн багш нарын тайлан (сургууль, хүйс, мэргэжлийн чиглэл)	Үндсэн багш нарийг мэргэжлийн чиглэлээр нь харуулна.
3	БДБ-10Б	ЕБС-ийн багш нарын тайлан (сургууль, нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн чиглэл)	Багш нарийн нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн чиглэл, багшилсан хугацаа, мэргэжлийн зэрэг (зөвлөх, заах аргач, тэргүүлэх) гэх мэт мэдээллийг харуулна.

БДБ 10 маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа:

1. Ажиллавал зохих багш -ийн дүнг **БДБ 10 тайланд** харуулахдаа энэ хичээлийн жилд ажиллаж байгаа багш дээр дутагдалтай багшийн тоог нэмж **Статистикийн удирдлага** -ын "**Байгууллагын асуулга**" үйл ажиллагааны **Багшийн мэдээлэл** хэсэгт бүртгэл хөтлөснөөр БДБ 10 тайлангийн ажиллавал зохих болон шаардлагатай багшийн тоо гарна.

2. Үндсэн багш-ийн тоо уг БДБ 10 тайланд орж ирээгүй тохиолдолд Боловсролын удирдлага -ын Багш үйл ажиллагаанд багш нарыг бүртгэж оруулахдаа Төрөл хэсэгт бага ангийн үндсэн , дунд ангийн үндсэн, ахлах ангийн үндсэн гэдэг сонголт хийсэн эсэхийг шалгана.

ЕБС -ийн ОРОЙ, ЭЧНЭЭГЭЭР ХИЧЭЭЛЛЭЖ БУЙ БҮЛГИЙН ТОО, СУРАЛЦАГЧДЫН ТАЙЛАН

Боловсролын удирдлага модулийн "Суралцагч" -ийн бүртгэлээс хамаарч БДБ-11, БДБ-11А, БДБ-11Б тайлангууд боловсруулагдана.

№	БДБ тайлангийн нэр		Тайлбар
1	БДБ-11	ЕБС-ийн орой, эчнээгээр хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын тайлан (нас, хүйс, анги)	Орой, эчнээ хөтөлбөрөөр хичээллэж байгаа суралцагчдын бүртгэлээс шууд боловсруулагдана. /Бүлэг, Суралцагчдын тоо, Нас, Өнчин эсэх, Хөгжлийн бэрхшээл/
2	БДБ-11А	ЕБС-ийн эчнээгээр хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын тайлан (нас, хүйс, анги)	ЕБС-ийн эчнээ хөтөлбөрөөр хичээллэж байгаа суралцагчдын бүртгэлээс шууд боловсруулагдана. /Бүлэг, Суралцагчдын тоо, Нас, Өнчин эсэх, Хөгжлийн бэрхшээл/
3	БДБ-11Б	ЕБС-ийн оройгоор хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын тайлан (нас, хүйс, анги)	ЕБС-ийн орой хөтөлбөрөөр хичээллэж байгаа суралцагчдын бүртгэлээс шууд боловсруулагдана. /Бүлэг, Суралцагчдын тоо, Нас, Өнчин эсэх, Хөгжлийн бэрхшээл/

Захиргааны мэдээлэл, Маягт БДБ-12

Дүйцсэн хөтөлбөрөөр хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын тоо, нас хүйс гэх мэт мэдээллийг харуулна.

№	БДБ тайлангийн нэр		Тайлбар
1	БДБ-12	Дүйцсэн хөтөлбөрөөр хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын тайлан (нас, хүйс)	Дүйцсэн хөтөлбөрөөр хичээллэж буй суралцагчдыг нас, хүйс, малчдын хүүхэд, бүтэн өнчин, хөгжлийн

			бэрхшээлтэй хүүхдийн тоо зэрэг мэдээлэл харагдана.
2	БДБ-12А	Дүйцсэн хөтөлбөрөөр хичээллэж буй бүлгийн тоо, суралцагчдын тайлан (сургууль, нас, хүйс)	Дүйцсэн хөтөлбөрөөр хичээллэж буй бүлгийн тоо болон суралцагчдын тоог харуулна.

Захиргааны мэдээлэл, Маягт БДБ-16.

БДБ-16 маягтаар тухайн сургуульд **суралцаж байгаа хүүхдүүдийн** сургалтын хэлбэр, хамран сургах тойргийн судалгаа, болон **сургуулийн** хэв шинж, ангилал, сургалтын төлбөр, хаягийн бүртгэл зэрэг мэдээлэл харагдана.

Тухайн бүртгэлийг шалгахдаа дараах байдлаар харна. Үүнд:

1. Маягтаар

БДБ -16 тайланг excel хэлбэрээр татан авч хянах боломжтой

2. Бүртгэлээр

Статистикийн удирдлага -ийн статистикийн хяналт хэсэгт орно.

Хяналтын хэсэгт хичээлийн жил болон тайлант үеийг сонгоно.

Нэгтгэл цонхноос **Байгууллага** болон **Суралцагч** гэсэн утгыг дуудна. Ингэснээрээ танай сургуулийн хэв шинж болон суралцагчийн сургалтын хэлбэрийн мэдээлэл нэгдсэн байдлаар харагдана.

Байгууллага:

Суралцагч:

БДБ-19 Шаардлагатай багшийн тайлан

№	БДБ тайлангийн нэр		Тайлбар
1	БДБ-19_2	ЕБС-ийн шаардлагатай багшийн тайлан (сургууль, мэргэжлийн чиглэл)	Төлөвлөгөөний асуулга бөглөснөөр гарна.

Анхааруулах нь: Уг асуулгыг бөглөхдөө зөвхөн одоо бүртгэлтэй багш нараас гадна шаардлагатай багшийн тоог оруулж илгээнэ.

БДБ-ДХШ-1-3 тайлан мэдээ зөв гаргах, шалгах, залруулах зааварчилгаа

Тайлбар: БДБ-ДХШ-1-3 тайлан нь ЕБС-д дүрэмт хувцас худалдан авах боломжгүй өрхийн суралцагчийн тайлан (сургууль, бага анги, хүйс, шалгуур үзүүлэлт)

Доорх мэдээллээс суралцагчийн мэдээлэл хэсэгт тохирох хариултыг бөглөсөн тохиолдолд БДБ-ДХШ1,2,3

тайлангийн Ш1,2,3,4,5,6 шалгууруудыг хангах боломжтой.

№	Шалгуур хангах хувилбар	Тайлбар
1	Ш1 шалгуурыг хангах	Дараах 2 хариултыг зэрэг сонгосон бол Ш1 шаардлагыг хангасанд тооцно: Боловсролын удирдлага системийн Суралцагч цэсний Суралцагчийн мэдээллийн Үндсэн мэдээлэл таб-ын 1. *Өнчний хэлбэр талбарт Бүтэн өнчин 2. *Асран хамгаалагч талбарт Асрамжлах хүнгүй
2	Ш2 шалгуурыг хангах	Дараах 2 хариултыг зэрэг сонгосон бол Ш2 шаардлагыг хангасанд тооцно: Боловсролын удирдлага системийн Суралцагч цэсний Суралцагчийн мэдээллийн Эрүүл мэнд таб-ын Хөгжлийн бэрхшээл дэд таб-ын 1. *Хөгжлийн бэрхшээлтэй талбарт Харааны, Сонсголын, Ярианы, Сэтгэцийн, Хөдөлгөөний, Хавсарсан хэлбэрийн сонголтуудын аль нэгийг. Нэмэлт мэдээлэл таб-ын Амьдрах орчин дэд таб-ын Өрхийн мэдээлэл хэсэг 2. Нэн ядуу өрх -ийг зөвлөх /check/
3	Ш3 шалгуурыг хангах	Дараах 2 хариултыг зэрэг сонгосон бол Ш3 шаардлагыг хангасанд тооцно: Боловсролын удирдлага системийн Суралцагч цэсний Суралцагчийн мэдээллийн Үндсэн мэдээлэл таб-ын 1. *Өнчний хэлбэр талбарт Эцэггүй эсвэл Эхгүй Нэмэлт мэдээлэл таб-ын Амьдрах орчин дэд таб-ын Өрхийн мэдээлэл хэсэг 2. АБТ-ээс доогуур орлоготой өрх -ийг зөвлөх /check/
4	Ш4 шалгуурыг хангах	Дараах 2 хариултыг зэрэг сонгосон бол Ш4 шаардлагыг хангасанд тооцно: Боловсролын удирдлага системийн Суралцагч цэсний Суралцагчийн мэдээллийн Нэмэлт мэдээлэл таб-ын Амьдрах орчин дэд таб-ын

		<p>Өрхийн мэдээлэл хэсэг</p> <p>1. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх -ийг зөвлөх /check/</p> <p>2. Эцэг, эх нь хоёулаа тэтгэвэр тогтоолгосон өрх -ийг зөвлөх /check/</p>
5	Ш5 шалгуурыг хангах	<p>Дараах 2 хариултыг зэрэг сонгосон бол Ш5 шаардлагыг хангасанд тооцно:</p> <p>Боловсролын удирдлага системийн Суралцагч цэсний Суралцагчийн мэдээллийн Нэмэлт мэдээлэл таб-ын Амьдрах орчин дэд таб-ын Өрхийн мэдээлэл хэсэг</p> <p>1. Эцэг, эх нь хоёулаа ажилгүй өрх -ийг зөвлөх /check/</p> <p>2. АБТ-ээс доогуур орлоготой өрх -ийг зөвлөх /check/</p>
6	Ш6 шалгуурыг хангах	<p>Дараах хариултыг сонгосон бол Ш6 шаардлагыг хангасанд тооцно:</p> <p>Боловсролын удирдлага системийн Суралцагч цэсний Суралцагчийн мэдээллийн Нэмэлт мэдээлэл таб-ын Амьдрах орчин дэд таб-ын Өрхийн мэдээлэл хэсэг</p> <p>1. 3 ба түүнээс дээш хүүхэд ЕБС-д сурдаг -ийг зөвлөх /check/</p>

Зам	Асуулт / Талбар	Хариулт	Хариулах хэлбэр
Боловсролын удирдлага/ Суралцагч/ Суралцагчийн мэдээлэл / Үндсэн мэдээлэл/	*Өнчний хэлбэр	Өнчин биш	Нэг сонголттой
		Эцэггүй	
		Эхгүй	
		Бүтэн өнчин	
	*Асран хамгаалагч	Эцэг, эх	Нэг сонголттой
		Эцэг	
		Эх	
		Төрөл садан	
		Асрамжийн газрын хүмүүжүүлэгч	
		Дотуур байрны хүмүүжүүлэгч	
Боловсролын удирдлага/ Суралцагч/ Суралцагчийн мэдээлэл / Эрүүл мэнд / Хөгжлийн бэрхшээл / Үндсэн мэдээлэл	*Хөгжлийн бэрхшээлтэй	Асрамжлах хүнгүй	Нэг сонголттой
		Бусад	
		Үгүй	
		Харааны	
		Сонсголын	
		Ярианы	
Сэтгэцийн			
		Хөдөлгөөний	

		Хавсарсан хэлбэрийн	
Боловсролын удирдлага / Суралцагч / Суралцагчийн мэдээлэл / Нэмэлт мэдээлэл /Амьдрах орчин / Өрхийн мэдээлэл	Нэн ядуу өрх	Тийм/Checkbox	Checkbox
	АБТ-ээс доогуур орлоготой өрх	Тийм/Checkbox	Checkbox
	Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх	Тийм/Checkbox	Checkbox
	3 ба түүнээс дээш хүүхэд ЕБС-д сурдаг өрх	Тийм/Checkbox	Checkbox
	Эцэг, эх нь хоёулаа ажилгүй өрх	Тийм/Checkbox	Checkbox
	Эцэг, эх нь хоёулаа тэтгэвэр тогтоолгосон өрх	Тийм/Checkbox	Checkbox

Код	Шалгуурын дугаар	Шалгуур	Шалгуур хангах	Шалгуурын заавар 2 /тайлбар/	Хөнгөлөх хувь
Ш1	1	Бүтэн өнчин	Зэрэг хангах	Ш1: Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй суралцагч	100%
	2	Асран хамгаалагчгүй			
Ш2	3	Нэн ядуу өрх	Зэрэг хангах	Ш2: Нэн ядуу өрхийн хөгжлийн бэрхшээлтэй нэг суралцагч	100%
	4	Хөгжлийн бэрхшээлтэй			
Ш3	5	Хагас өнчин	Зэрэг хангах	Ш3: Хагас өнчин бөгөөд ҮСГ-аас тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой өрхийн нэг суралцагч	90%
	6	АБТ-ээс доогуур орлоготой өрх			
Ш4	7	Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх	Зэрэг хангах	Ш4: Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх болон эцэг эх нь хоёулаа тэтгэвэрт гарсан өрхийн нэг суралцагч	90%
	8	Эцэг, эх нь хоёулаа тэтгэвэр тогтоолгосон өрх			
Ш5	9	Эцэг, эх нь хоёулаа ажилгүй өрх	Зэрэг хангах	Ш5: Эцэг эх нь хоёулаа ажилгүй, ҮСГ- аас тогтоосон амжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой өрхийн нэг	80%

	10	АБТ-ээс доогуур орлоготой өрх		суралцагч	
Ш6	11	3 ба түүнээс дээш хүүхэд ЕБС-д сурдаг өрх	Хангах	Ш6: 3 ба түүнээс дээш хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа өрхийн нэг суралцагч	70%

1. ЕБС - Ажилтан ажлын ангилал, код

1. ЕБС - Ажилтны ажлын ангилал, код

ЕБС -ийн хувьд ажлын байр, орон тоог үүсгэхдээ "Ажлын ангилал" талбарт дараах кодтой ажлын байр орон тоог үүсгэж байж БДБ тайланд ажилтан, албан хаагчидтай холбоотой мэдээлэл үнэн зөв гарна.

[Багшийн ангилалын энд дарж харна уу.](#)

БДБ7 тайлан

2. ЕБС - Багшийн ажлын ангилал, код

2. ЕБС - Багшийн ажлын ангилал, код

ЕБС -ийн Багшийн ажлын байр, орон тоог үүсгэхдээ "Ажлын ангилал" талбарт дараах кодтой ажлын байр орон тоог үүсгэж байж СӨБ тайланд ажилтан, албан хаагчидтай холбоотой мэдээлэл үнэн зөв гарна.

3. АББ - Ажилтны ангилал, код

3. Албан бус боловсролын төвийн багш ажилтан

Албан бус боловсролын төвийн ажилтныг системд бүртгэх ажлын ангилал болон кодыг жагсаалтаар харуулав.

Энэ жагсаалт нь БДБ-7.1 ба БДБ-7.1А тайланд хамаарах багш, ажилтанд хамааралтай болно.

4. Сургалтын орчин БДБ18 тайлангийн үзүүлэлт бодох зааварчилгаа

5. Номын сан буюу СУ-17 тайланг системээс хэрхэн гаргах зааварчилгаа

6. Нийт хөрөнгө болон төсвийн гүйцэтэлийн тайланг системээс гаргах зааварчилгаа

7. Төгсөлт, сурлагын амжилт, шаардлагатай багшийн тайлан гаргах зааварчилгаа

ЕБС -ийн төгсөлт явагдаж дууссаны дараа хичээлийн жил дуусахаас өмнө дор дурьдсан статистик тайлангуудыг сургуулиуд илгээнэ.

№	БДБ тайлангийн нэр		Тайлбар
1	БДБ-19_2	ЕБС-ийн шаардлагатай багшийн тайлан (сургууль, мэргэжлийн чиглэл)	Төлөвлөгөөний асуулга бөглөснөөр гарна.
2	БДБ-20	ЕБС-ийн төгсөгчдийн тайлан (сургалтын хэлбэр, хүйс)	Системд хийгдсэн төгсөлтийн бүртгэл үйлдлээс харуулна.
3	БДБ-20.Б	Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын төгсөгчдийн тайлан (нас, хүйс)	ЕБС-д шилжүүлсэн хүүхдийн тоо Дүйцсэний асуулга бөглөснөөр гарна.
4	БДБ-21.1.1	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (бага анги, хичээл, өдөр)	Дэвших ангийн дэвшилт батлагдсан, төгсөх анги бол төгсөлт төгсөгчөөс элсэх үйлдэл батлагдсанаар мэдээлэл татагдана.
5	БДБ-21.1.2	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (бага анги, хичээл, дүйцсэн)	
6	БДБ-21.1.3	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (бага анги, хичээл, орой)	
7	БДБ-21.1.4	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (бага анги, хичээл, эчнээ)	
8	БДБ-21.2.1	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (Дунд анги, хичээл, өдөр)	
9	БДБ-21.2.2	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (Дунд анги,	

		хичээл, дүйцсэн)
10	БДБ-21.2.3	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (Дунд анги, хичээл, орой)
11	БДБ-21.2.4	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (Дунд анги, хичээл, эчнээ)
12	БДБ-21.3.1	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (Ахлах анги, хичээл, өдөр)
13	БДБ-21.3.2	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (Ахлах анги, хичээл, дүйцсэн)
14	БДБ-21.3.3	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (Ахлах анги, хичээл, орой)
15	БДБ-21.3.4	Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тайлан (Ахлах анги, хичээл, эчнээ)

Анхаарах нь

1. Тайлангуудыг Статистикийн удирдлагын модулийн **Статистикийн хяналт** хэсэгт боловсруулна.
2. Тайлангийн мэдээллийг татахаас өмнө Бүгдийг шинэчлэх товчийг нэг удаа дарна. Дараа нь мэдээллээ өөрчилсөн бол тохирох мэдээллийн арын шинэчлэх товчийг дарж тайланг бодуулж эксэл рүү гаргаж харна.

2. Хэрэв алдаа гарсан бол мэдээлэл руу орж алдааг засаж мэдээллийг шинэчилж татна.
3. Дараах дараалалаас тайлангийн мэдээллийг шалгаж, бүрэн зөв хийгдсэн гэж үзвэл илгээх үйлдэл хийнэ.
 1. Мэдээллийг нэг удаа **Бүгдийг** шинэчлэх товчоор мэдээллийг татна. Мэдээллийг засаж, өөрчилсөн бол тохирох мэдээллийн арын шинэчлэх товчийг дарж мэдээллийг шинэчилж татна.
 2. Алдаа гарсан бол алдааг үндсэн систем руугаа орж засна (шинэчлэх)
 3. Тайланг **бодох** үйлдлийг хийнэ
 4. **Эксэл рүү** гаргаж тайланг хянаж шалгана.
 5. Бүх тайланг хянаж, бүрэн зөв болсон гэж үзвэл **Илгээх** үйлдэл хийнэ.
4. Дүйцсэн, орой, эчнээ ангигүй бол тайланг хоосноор бодуулна.

• **БДБ19_2 ЕБС-д шаардлагатай багшийн тайлан**

ЕБС-д шаардлагатай багшийн тайлан нь ирэх хичээлийн жилд сургуульд дутагдалтай байгаа багшийн тоог илэрхийлнэ.

Тайлангийн бодолт:

Статистикийн удирдлагын системийн Төлөвлөгөөний асуулга)-д байрлах **шаардлагатай багшийн тоо** асуулгыг бөглөж хадгалснаар энэхүү тайлан гарна.

• **БДБ20 ЕБС-ийг төгсөгчдийн тайлан (Сургалтын хэлбэр, хүйс)**

Тайлангийн бодолт:

Хичээлийн жилийн эхний суралцагчид:

Намрын өдөр, эчнээ, орой, дүйцсэн ангийн тайлангийн бага боловсрол (5-р анги), суурь боловсрол (9-р анги), бүрэн дунд боловсрол (12-р анги)-д суралцаж буй хүүхдийн тоо

Хичээлийн жилийн эцсийн суралцагчид:

Сургуульд бүртгэлтэй нийт суралцагчийн тоо

Шалгагдсан:

Төгсөх анги буюу бага боловсрол (5-р анги), суурь боловсрол (9-р анги), бүрэн дунд боловсрол (12-р анги)-д суралцаж байгаа улсын шалгалт өгсөн суралцагчийн тоо

Төгссөн:

Төгсөх анги буюу бага боловсрол (5-р анги), суурь боловсрол (9-р анги), бүрэн дунд боловсрол (12-р анги)-ыг төгсөгчдийн тоо (төгсөлтийн бүртгэл батлагдсан)

- ***БДБ20Б Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын төгсөгчдийн тайлан***

Дүйцсэн хөтөлбөрөөр төгсөгчид:

Дүйцсэн хөтөлбөрийн бага боловсрол (5-р анги), суурь боловсрол (9-р анги), бүрэн дунд боловсрол (12-р анги)-ыг төгсөгчдийн тоо

ЕБС-д шилжүүлсэн хүүхдийн тоо:

Статистикийн удирдлагын системийн Дүйцсэний асуулга-д байрлах Дүйцсэн хөтөлбөрийн суралцагчийн ЕБС-д шилжүүлсэн хүүхдийн тоо мэдээллийг бөглөснөөр гарна.

- ***БДБ20Б (Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын төгсөгчдийн тайлан)***

Дүйцсэн хөтөлбөрөөр төгсөгчид:

Дүйцсэн хөтөлбөрийн суурь боловсрол (9-р анги), бүрэн дунд боловсрол (12-р анги)-ыг төгсөгчдийн тоо

Ерөнхий боловсролын сургуульд шилжүүлсэн хүүхдийн тоо:

Статистикийн удирдлагын системийн Дүйцсэний асуулга-д байрлах дүйцсэн хөтөлбөрийн суралцагч асуулгыг бөглөсөн байдлаар энэхүү мэдээлэл гарна.

- ***БДБ21.1.1 (Суралцагчдын мэдлэг, чадварын ахиц, амжилтын үнэлгээний тайлан)-Бага, өдөр***

Суралцагчдын мэдлэг, чадварын ахиц, амжилтын үнэлгээг боловсролын түвшингээр (1-5-р ангийн) хичээлийн дүн орж, дэвшилт, төгсөгчөөс элсэх бүртгэл баталгаажсан суралцагчийн тоог харуулна.

- ***БДБ21.2.1 (Суралцагчдын мэдлэг, чадварын ахиц, амжилтын үнэлгээний тайлан) Дунд, өдөр***

Суралцагчдын мэдлэг, чадварын ахиц, амжилтын түвшингийн боловсролын түвшингээр дунд (6-9-р ангийн) хичээлийн дүн орж, дэвшилт, төгсөгчөөс элсэх бүртгэл баталгаажсан суралцагчийн тоог харуулна.

- **БДБ21.3.1 (Суралцагчдын мэдлэг, чадварын ахиц, амжилтын үнэлгээний тайлан) Ахлах, өдөр**

Суралцагчдын мэдлэг, чадварын ахиц, амжилтын түвшингийн боловсролын түвшингээр ахлах (10-12-р ангийн) хичээлийн дүн орж, дэвшилт, төгсөгчөөс элсэх бүртгэл баталгаажсан суралцагчийн тоог харуулна.

8. Сурах бичиг, Сурдаггүй хүүхэд тайлан гаргах зааварчилгаа

"Сурах бичиг, Сурдаггүй хүүхэд" тайлан боловсруулах

Суралцагчдын сурах бичгийн судалгаа, статистик удирдлага модулийн "Сурдаггүй хүүхэд" дэд модулийн бүртгэлээс хамаарч дараах тайлангууд боловсруулагдана.

№	БДБ тайлангийн нэр		Тайлбар
1	БДБ14	ЕБС-ийн сурах бичгийн хангалтын тайлан (бага анги)	Анги удирдсан багшийн бүртгэсэн суралцагчдын сурах бичгийн бүртгэлээс шууд боловсруулагдана. Суралцагч -> Суралцагчийн нэр -> Нэмэлт мэдээлэл -> Ном сурах бичиг
2	БДБ14_1	ЕБС-ийн сурах бичгийн хангалтын тайлан (дунд, ахлах анги)	
3	БДБ14_2	ЕБС-ийн казак хэл дээрх сурах бичгийн хангалтын тайлан (бага анги)	
4	БДБ14_2_1	Казах сурах бичигтэй сургуулийн тайлан	
5	БДБ15	ЕБС-ийн гадна байгаа 6-14 насны хүүхдийн тайлан (нас, хүйс, шалтгаан)	Статистик удирдлага модулийн " Сурдаггүй хүүхэд " дэд модулийн бүртгэлээс хамаарч боловсруулагдана.
6	БДБ15А	ЕБС-ийн гадна байгаа 6-14 насны хүүхдийн тайлан (сургууль, нас, хүйс, анги)	

"Сурах бичиг, Сурдаггүй хүүхэд" тайлант үе нээгдсэний дараа сургалтын менежер дараах бүртгэл үйл ажиллагааг хийнэ.

1. **Сургуульд сурдаггүй хүүхдийн бүртгэл хийж хадгалах** - Хэрэв тухайн сургуульд сурахгүй шалтгаантай суралцагч байдаг бол энэхүү бүртгэлээр хийнэ.

2. **Тайлан бодуулж excel-рүү татан, хянаж тоо таарч буй үед илгээх** - БДБ14, БДБ14_1, БДБ14_2, БДБ14_2_1, БДБ15, БДБ15А тайлангууд

1. Сургуульд сурдаггүй хүүхдийн бүртгэл хийж хадгалах

Статистикийн удирдлага -> Сурдаггүй хүүхэд -> Шинэ сурдаггүй хүүхэд сонголтоор бүртгэнэ.

2. Тайлан бодуулж excel-рүү татан, хянаж тоо таарч буй үед илгээх

Сурах бичиг, Сурдаггүй хүүхэд тайлант үе нээгдсэний дараа анги удирдсан багш нар суралцагч нэг бүрээр сурах бичгийн судалгааг бүртгэнэ. /Багш суралцагчдын сурах бичгийн бүртгэлийг хийх зааврыг дараах холбоосоор авна уу. <https://help.esis.edu.mn/content/946/> /

Дээрх бүртгэл бүрэн хийгдсэн үед сургалтын менежер

Статистикийн удирдлага -> Статистик хяналт дэд модулийг сонгоно.

1-рт: **Нэгтгэл -> Бүгдийг шинэчлэх** товчийг дарна. /Аливаа мэдээлэл шинэчлэн, нөхөж бүртгэсэн бол энэ товчийг заавал дарах юм. Хэрэв энэ товчыг дарсан бол тайлангуудыг дахин бодуулах шаардлагатай./

2-рт: **Тайлан - Хичээлийн жил, тайлангийн нэр** сонгож тайлангуудыг бодуулан excel -рүү татаж тоог тулган хянана.

3-рт: **Тайлангуудын** excel файлуудын бүх тоо таарч буй үед **илгээх** товчийг сонгоно.

Албан ёсны мэдээлэл, Маягт БДБ-15

- Сургуулийн гадна байгаа 6-14 насны хүүхдийн тоог нас, хүйсээр гарган тухайн сум, багийн Засаг даргын тамгын газраас гаргасан статистикийн мэдээлэлтэй тулган шалгасан байна.
 - Энэхүү мэдээллийг тухайн орон нутгийн нутаг дэвсгэр дээрх 6-14 насны хүн амын тоо болон сургууль завсардсан суралцагчдын судалгаанд үндэслэн ЕБС-ийн нийгмийн ажилтан, хорооны нийгмийн ажилтан, албан бус боловсролын арга зүйч хамтран гаргана.
 - Сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн бүтэн өнчин, асрамжлах хүнгүй зэрэг нийгмийн байдал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг 6-11 нас, 12-14 насны ангиллаар гаргана.
-